

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэл



ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ, ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт 735.2 сая ам.доллар байлаа.

2012 оны 1 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 735.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 32.0%-иар өсчээ. Нийт бараа эргэлтийн 42.1% буюу 309.4 сая ам.долларын худалдааг Хятад улстай, 23.9% буюу 175.5 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна.

Импортын хурдтай өсөлт хадгалагдсаар...

Тайлант хугацаанд нийт экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.2%-иар өсч 240.3 сая ам.долларт, импорт 42.1%-иар өсөн 494.9 сая ам.дол-

-ларт тус тус хүрчээ. Импортын өсөлтийн хурд экспортынхоос 2.8 дахин илүү байснаар нийт гадаад худалдааны алдагдал 254.6 сая ам.долларт хүрэв. Үүнээс валютаар төлбөр нь хийгддэг барааны гадаад худалдааны алдагдал 171.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.9 дахин өсөөд байна.

Гадаад худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт оны эхний сард эерэг байлаа.


2012 оны 1 дүгээр сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс¹ 1.645-д хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.2%-иар өслөө. Гадаад худалдааны нөхцөлийн индексийн өсөлтөд импортын машин тоног төхөөрөмжийн үнэ өнгөрсөн оны мөн үеэс буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны эргэлт /сая ам.доллар/

	Эхний 1 сар		Δ%
	2011	2012	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	556,8	735,2	32,0%
▪ Валютын төлбөртэй бараа	506,3	651,9	28,8%
Экспорт	208,6	240,3	15,2%
▪ Валютын төлбөртэй бараа	208,6	240,2	15,2%
Импорт	348,2	494,9	42,1%
▪ Валютын төлбөртэй бараа	297,7	411,7	38,3%
Гадаад худалдааны тэнцэл	-139,6	-254,6	1,8x
▪ Валютын төлбөртэй бараа	-89,1	-171,5	1,9x


Эх сурвалж: ГЕГ

Зураг 1. Гадаад худалдааны эргэлт, сараар /сая ам.доллар/




Эх сурвалж: ГЕГ

Зураг 2. Худалдааны нөхцөлийн индекс, сараар



Эх сурвалж: Монголбанк

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индексийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

¹ Экспортод дунджаар 90 орчим хувийг эзэлдэг 10 бүтээгдэхүүн, импортод дунджаар 88 орчим хувийг эзэлдэг 7 бүлэг бүтээгдэхүүний хувьд худалдааны нөхцөлийн индексийг 2000 оныг суурь болгон тооцов.

Чулуу нүүрсний экспорт нийт экспортын 31.2 хувийг бүрдүүлж байна.


2012 оны 1 дүгээр сарын байдлаар 240.3 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 15.2% буюу 31.7 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Мөн хугацаанд нийт экспортын 31.2%-ийг чулуу нүүрс, 27.8%-ийг зэсийн баяжмал, 15.7%-ийг төмрийн хүдэр ба баяжмал, 8.1%-ийг боловсруулаагүй нефть тус тус бүрдүүлж байна. Тус хугацаанд “Бороо Гоулд” ХХК 158.6 кг алтыг Канад улсад экспортолсон байна.

Чулуу нүүрс, молибдений хүдэр ба баяжмал, ямааны угаасан самнасан ноолуурын экспортын биет хэмжээ буурснаар нийт экспорт 16.5 сая ам.доллараар буурахаар байсан боловч (i) зэсийн баяжмал, (ii) төмрийн хүдэр, (iii) боловсруулаагүй нефть, (iv) жонш, лейцит, нефелинт сиенитийн биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 35.8 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний экспортын үнийн өсөлтөөс шалтгаалан 41.1 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс өсөхөд нөлөөлжээ.

Экспортын түүхий эдийн үнэ буурч байна.

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2012 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр унц тутамд 1738.1 ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 30.7%-иар, өмнөх сараас 10.5%-иар тус тус өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2011 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар 8299.5, 2087.8 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 15%, 13%-иар буурсан ч, өмнөх сараас тус тус 9.3%, 14.3%-иар өссөн байна.

Зураг 5. Лондонгийн металлын бирж дэх зэс, цайр болон дэлхийн зах зээл дэх алтны үнэ /ам.доллар/




Эх сурвалж: Bloomberg

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 1 сар				Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/
	2011		2012		
	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	
1 Чулуун нүүрс	665 096	39,9	634 281	75,0	87,9% ↑
2 Зэсийн баяжмал	45 212	74,8	48 099	66,7	-10,9% ↓
3 Төмрийн хүдэр ба баяжмал	252 069	21,1	513 092	37,7	78,9% ↑
4 Боловсруулаагүй нефть	135 991	11,9	201 632	19,4	62,5% ↑
5 Цайрын хүдэр ба баяжмал	19 056	21,2	8 016	8,1	-62,0% ↑
6 Мөнгөжөөгүй алт	70	2,7	159	7,0	155,4% ↑
7 Жонш, лейцит, нефелинт ба нефелинт сиенит	34 737	5,8	24 778	5,7	-1,1% ↓
8 Молибдений хүдэр ба баяжмал	313	3,6	294	2,8	-22,5% ↑
9 Ямааны угаасан ноолуур	0	0,0	14	0,5	-
10 Ямааны самнасан ноолуур	6,4	0,6	0,5	0,1	-90,6% ↓
Бусад		27,0		17,4	-35,6% ↑
Нийт экспорт		208,6		240,3	15,2% ↑

Эх сурвалж: ГЕГ

Зураг 4. Экспортын өөрчлөлт дэх үнийн болон тоо хэмжээний нөлөөлөл /сая ам.доллар/



Эх сурвалж: ГЕГ

Зураг 6. Чулуун нүүрсний зах зээлийн үнэ /ам.доллар/



Эх сурвалж: ГЕГ, ЭБЭХЯ

Өвөрмонголын зах зээл дэх нүүрсний дундаж үнэ 2011 оны 12 дугаар сарын байдлаар тонн тутамд 114.7 ам.долларт хүрч оны эхнээс 1.5 дахин өссөн байна. Харин Монгол Улсын экспортын нүүрсний хилийн дундаж үнэ тонн тутамд 114.2 ам.долларт хүрч өмнөх сараас 4.3 хувиар буурсан байна.

² Экспортын үнэ нь худалдааны түнш хооронд гэрээгээр тохирсон болон бүс нутгийн зах зээл дэх үнийг илэрхийлнэ.


ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, ТҮҮХИЙ ЭД

Импортын өсөлт үргэлжилсээр...

2012 оны 1 дүгээр сарын байдлаар нийт импорт 494.9 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 42.1 хувиар буюу 146.7 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд: i) нефтийн импорт 2.2 дахин өсч 143.3 сая ам.долларт, ii) тээврийн хэрэгслийн импорт 1.2 дахин өсч 83.0 сая ам.долларт, iii) хүнд машин, механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн импорт 1.1 дахин өсч 76.0 сая ам.долларт тус тус хүрсэн нь голлон нөлөөлжээ.


Нийт импортын 83.2% буюу 411.7 сая ам.долларыг валютын төлбөртэйгээр, 14.0% буюу 69.0 сая ам.долларыг хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа эзэлж байна.

Зураг 7. Монгол улсын нефтийн импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: ГЕГ

Зураг 8. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ



Эх сурвалж: Bloomberg

Дүгнэлт: Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2012 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 32.0%-иар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 11.8%-иар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 49.1%-иар өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт 3. Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 1 сар		Өөрчлөлт /хувиар/
	2010	2011	
1 Нефтийн бүтээгдэхүүн	64,1	143,3	123,6% ↑
2 Тээврийн хэрэгсэл	66,8	83,0	24,1% ↑
3 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	69,2	76,0	9,8% ↑
4 Хүнсний бүтээгдэхүүн	14,5	18,9	30,3% ↑
6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	13,0	16,9	29,2% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	3,6	7,8	113,7% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	0,3	1,3	310,4% ↑
8 Төрөл бүрийн даавуу	0,1	0,1	-17,8% ↓
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	12,9	15,6	21,1% ↑
Бусад	103,5	132,1	27,6% ↑
Нийт импорт	348,2	494,9	42,1% ↑

Эх сурвалж: ГЕГ

Нефтийн хилийн дундаж үнэ өсөж байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын нефтийн импортын биет хэмжээ өнгөрсөн оноос 51.5%-иар, хилийн дундаж үнэ 48.5%-иар тус тус өссөнөөр нийт нефтийн импорт мөнгөн дүнгээр 143.3 сая ам.долларт хүрчээ.

Нефтийн импортын хилийн дундаж үнэ 2012 оны 1 дүгээр сард тонн тутамд 1264.4 ам.долларт хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 36.7%-иар, өмнөх сараас 1.9%-иар тус тус өсөөд байна.

Түүнчлэн, 2012 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар дэлхийн зах зээл дээрх Brent маркийн газрын тосны үнэ баррель тутамд 111.6 ам.долларт хүрч өмнөх сараас 2.7%-иар өссөн бол, WTI газрын тосны үнэ баррель тутамд 98.5 ам.долларт хүрч өмнөх сараас 0.5%-иар буурсан байна.